



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар Д/248

Хэрлэн сум


“Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арвандолоодугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших, иргэд аж ахуй нэгжийг дэмжих “Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

“Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийн 2023-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Зорилт/Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Шаардагдах хөрөнгийн хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэрэгжүүлэгч байгууллага	Хугацаа
Зорилго 1. Иргэд шилжин суурьшихад тулгардаг хүндрэлийг бууруулж Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэдийн тоог 10 хувиар нэмэгдүүлэх								
1.1	УБ хотоос орон нутаг ирж ажиллаж, амьдарч байгаа бүртгэлгүй иргэдийн судалгааг гаргаж тухайн орон нутагтаа бүртгэлжүүлэх	Судалгаа гаргаж, бүртгэлжүүлсэн эсэх	Бүртгэл, судалгаа байхгүй.	Сум бүр судалгаатай болж, бүртгэлгүй иргэдийг 100 хувь бүртгэлд хамруулсан байна.			Сум, багийн Засаг дарга нар	2 дугаар улиралд
1.2	Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгүүлэх ажлыг иргэдэд сурталчилж, үйлчилгээг нэмэгдүүлэх	Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо	0	Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо өссөн байна.			Улсын бүртгэлийн хэлтэс	1-4 дүгээр улиралд
1.3	Анхан шатны нэгжийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах	Бүртгэлтэй холбоотой санал, гомдол гарсан эсэх	0	Шилжилт хөдөлгөөний бүртгэл нь харъяалал харгалзах бүртгэл тул тухайн бүртгэлийн нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй, доголдолгүй үзүүлсэн байна.			Улсын бүртгэлийн хэлтэс	2 дугаар улиралд
1.4	Холбогдох хууль, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж хүргүүлэх	Нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн эсэх (хууль, журмын тоо)	0	10-аас доошгүй хууль, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж хүргүүлсэн байна.			АИТХ, ХЭЗХ, Татварын хэлтэс, УБХ, ГХБХБГ	2 дугаар улиралд

1.5	Орон нутагт шилжин ирж буй иргэдэд шилжилт хөдөлгөөний талаар цогц мэдээлэл өгөх, арга зүйгээр хангах үйлчилгээг үзүүлдэг анхан болон унд шатны төрийн албан хаагчдыг "Сургагч ажилтан"-д бэлтгэх, сургагч ажилтнаар дамжуулан сумдын албан хаагчдын шилжин ирж байгаа иргэдтэй ажиллах чадавхыг бэхжүүлэх	Сургагч ажилтны тоо		60 төрийн албан хаагч хамрагдсан байна.	2,0 сая төгрөг		Сургагч багш нар	1 дүгээр улиралд
1.6	"Нээлттэй Хэнтий аймаг уулзалт, өдөрлөг"-ийг Засаг даргын ивээл дор зохион байгуулах	Мэдээлэл хүргэж, хандалт авсан иргэд, ААН-ийн тоо	0	Иргэд, ААН, олон нийтэд мэдээлэл түгээж, аймаг орон нутгаа сурталчилсан байна.	5.0		АЗДТГ	2 дугаар улиралд
1.7	Сумдын хөтөлбөр, төлөвлөгөө батлуулан сум бүр шилжин ирэгсдийн тоог 10 хувиар нэмэгдүүлэх	Хэнтий аймаг, сумдад шилжин ирэгсдийн хувь	79429	Хэнтий аймаг, сумдад шилжин ирэгсдийн тоо 10 хувиар буюу 87372-ээр нэмэгдсэн байна.			Аймаг, сумын ЗДТГ	4 дүгээр улиралд
Зорилго 2. Орон нутагт иргэдийг шилжин суурьшихад дэмжих, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх								
2.1	"Хөрөнгө оруулагчдын нэгдсэн чуулган"-ыг орон нутагтаа зохион байгуулах	Оролцогчдын тоо, үр дүн		Томоохон хөрөнгө оруулагчдыг орон нутагтаа татах, шилжүүлэн авчрах чиглэлээр дэмжсэн байна.	20.0 сая		Аймгийн ЗДТГ, ХБТХОХ	2 дугаар улиралд
2.2	Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөж байгаа оюутан залууст чиглэсэн "Нутгаа	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, мэдээлэл хүргэсэн оюутны тоо		Орон нутаг дахь ажлын байрны өдөрлөг зохион байгуулж, оюутан залууст мэдээлэл түгээсэн байна.	30.0 сая		АЗДТГ, ХХҮГ СЗДТГ, ТББ-уудтай хамтрах /Оюутны холбоо/	3 дугаар улиралд

	зорьё" өдөрлөгийг сум бүр зохион байгуулах							
2.3	УБ хотод байршиж буй цэргийн зарим анги, салбарыг аймаг руу үе шаттайгаар шилжүүлэх	Шилжүүлж ирсэн Цэргийн анги салбарын тоо		Тодорхой анги, салбар орон нутагт шилжин байрласан байна.			АЗДТГ-ын Цэргийн штаб	Тухайн жилд
2.4	Орон нутагт ажиллах төрийн захиргааны албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах	Төрийн захиргааны албан хаагчийн цалингийн нэмэгдэл /хувиар/		Төрийн албаны тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс цалинждаг байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн 20 хувийн нэмэгдэл цалин олгосон байна.	2 тэрбум		АЗДТГ	2 дугаар улиралд
2.5	Орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг тус тус сайжруулах	Сайжруулсан боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний тоо, чанарын үзүүлэлт		Боловсрол, эрүүл мэндийн 10-аас багагүй үйлчилгээний чанарын үзүүлэлтийг тус бүр 50-аас дээш хувиар сайжруулсан байна.			АЗДТГ	Тухайн жилд
2.6	Цахим системийг босоо удирдлагад шилжүүлэх байдлаар төрийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулах, орон нутагт цахим аймаг шилжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Цахим үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо, цахимжуулсан үйлчилгээний хувь		Иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг төрийн 8 байгууллага үйлчилгээгээ 100 хувь цахимжуулсан байна.			ГХБХБГ, НДХ, УБХ, ТХ, ЭМД, ХХҮГ, АТТ, ШШГГ	Тухайн жилд
Зорилго 3. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгжийн уялдааг хангах								
3.1	Орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, иргэд, ААН шилжин ирэх таатай нөхцлийг бүрдүүлэх	Мэдээлэл хүргэсэн иргэд, ААН-ийн тоо, хандалт		Газар олголт, барилга орон сууц, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бизнесийн			АЗДТГ-ын ХБТХОХ	1 дүгээр улиралт

	чиглэлээр нээлттэй мэдээлэл хүргэнэ.			таатай орчин, эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, татварын бодлого болон орон нутгийн давуу талуудыг тодорхойлж нийтэд нээлттэй хүргэнэ.				
3.2	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан бодлогоор дэмжиж орон нутагт татах, хамтран ажиллах	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тоо		Олон улсын болон Улсын төсвөөр хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг аймаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулж, бодлогоор дэмжиж, зохих шийдвэрүүдийг гаргаж ажилласан байна.			АЗДТГ-ын ХБТХОХ	Тухайн жилд
3.3	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж, иргэд, ААН-тэй хамтран ажиллана.	Шинээр бий болсон үйлдвэр, ААН-ийн тоо, шинээр бий болгосон ажлын байрны тоо		Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, шинээр үйлдвэр үйлчилгээ бий болгох иргэд, ААН-ийг бодлогоор дэмжиж, ажлын байр нэмэгдүүлсэн байна.			АЗДТГ-ын ХБТХОХ	Тухайн жилд
3.4	Шилжин ирж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн газрын асуудлыг шийдвэрлэж газар олгох	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан шилжин ирэгсдийн хувь		Орон нутагт шилжин суурьшсан иргэдэд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд			ГХБХБГ	Тухайн жилд

				гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгох газрын 20 хувь буюу 471 иргэнд 36.7 га газрыг олгосон байна. Аж ахуйн нэгжийн саналын дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотголоор оруулж, дуудлага худалдаагаар шийдвэрлэх				
3.5	УБ хотоос шилжин ирсэн иргэд, ААН-ийн бизнесийг өргөжүүлэх дэмжих зорилгоор иргэдэд 50 сая хүртэлх, аж ахуйн нэгжид 500 сая хүртэлх төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгох Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлнэ.	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэд, ААН-ийн тоо		УБ хотоос шилжин ирсэн иргэд, ААН-ийн бизнесийг өргөжүүлэх дэмжих зорилгоор иргэдэд 50 сая хүртэлх, аж ахуйн нэгжид 500 сая хүртэлх төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгох Засгийн газрын шийдвэрийн талаар мэдээлэл түгээж, иргэд, ААН-ийг хамрагдах нөхцлийг бүрдүүлж ажиллана.			АЗДТГ-ын ХБТХОХ	Тухайн жилд
3.6	Орон нутагт шилжин тогтвор суурьшилтай амьдарч, ажиллах иргэд, гэр бүл, өрхөд чиглэсэн эдийн засгийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Хамрагдсан иргэд, өрхийн тоо		Орон нутагт шилжин очиж байгаа ипотекийн зээлд хамрагдах иргэдэд 3%-ийн хүүтэй зээл олгож, урьдчилгаа төлбөр 30%-ийн 60%-д баталгаа, батлан даалт гаргах, тогтвор			АЗДТГ-ын ХБТХОХ	Тухайн жилд

				суурьшилтай амьдарч, ажиллаж байгаа өрхийн хүүхдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх				
3.7	Орон нутагт шинээр салбараа нээж ажлын байр нэмэгдүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх	Шилжин ирэгсдэд зориулсан дэмжлэг урамшууллын тоо, хамрагдсан иргэн, ААН-ийн тоо		Иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууцыг татвараас чөлөөлнө. Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш таван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг 100 хувь татвараас хөнгөлнө. Албан татвар төлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх дулаан, цахилгаан үйлдвэрлэх төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан			ХХҮГ, НДХ, Татварын хэлтэс	Тухайн жилд

				татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 3 жил 90 хувь, дараагийн 3 жил 50 хувиар хөнгөлнө.				
3.8	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварыг Улаанбаатар хотоос алслагдсан хэмжээг харгалзан ялгамжтай тогтоон, дийлэнхийг орон нутгийн мэдэлд шилжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх	Тухайн чиглэлээр олгосон хөнгөлөлттэй зээлийн тоо		Хөгжлийн хөтөлбөр, бүс нутгийн хөгжлийг хурдасгах төсөл хэрэгжүүлэх сонирхол бүхий аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагад хуульд заасан татварын хөнгөлөлт, урт хугацааны хүүгүй, хүү багатай зээл, барьцаа хөрөнгө шаардахгүй зээл олгох шийдвэрүүд гарсан байна.			ХХҮГ, Татварын хэлтэс	Тухайн жилд
3.9	Орон нутагт хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд татварын дэмжлэг үзүүлэх	Татварын дэмжлэг үзүүлэх боломж нөхцөл бүрдсэн эсэх		Орон нутагт хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн төлсөн хувь хүний орлогын албан татварыг тодорхой хугацааны дараа шалгуур хангасан тохиолдолд буцаан олгодог болгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөх хэмжээ, хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн тодорхой хөшүүрэг бий болгосон байна.			НДХ, УБХ, Татварын хэлтэс	Тухайн жилд


				Иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууцыг татвараас чөлөөлнө.			
3.1 0	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх, боловсруулах чиглэлээр шинээр байгуулагдах үйлдвэрийг татвараас тодорхой хувиар чөлөөлөх	Татварын чөлөөлөлтөд хамрагдсан үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо		Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийг татвараас 100% чөлөөлсөн байна. Экспортлох зориулалттай үйлдвэрлэл эрхлэх болон ажлын байр олноор нэмэгдүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид эхний ээлжид зээл олгох, бий болгосон ажлын байрны тоог харгалзан татварын хөнгөлөлт үзүүлнэ.			ХХААГ, Татварын хэлтэс Тухайн жилд
3.1 1	Хөдөө аж ахуйг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийн үр өгөөжийг шилжин ирэгсдэд чиглүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан шилжин ирэгсдийн тоо, үр өгөөж		Малжуулах төсөлд шилжин ирэгсдийг хамруулах, шинэ залуу малчин бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинэ цагийн илгээлтийн эзэд хөдөлгөөнийг өрнүүлж, үр дүнг дүгнэсэн байна.			ХХҮГ, ХХААГ, СЗДТГ Тухайн жилд
3.1 2	Аж үйлдвэрийн паркийг Бор-Өндөр суманд байгуулах ажлыг	Дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ хувиар		1-ээс доошгүй үйлдвэр бий болж, Дотоодын хөрөнгө	5 тэрбум		Бор-Өндөр сумын ЗДТГ Тухайн жилд

	эхлүүлж, тус бүс нутаг дахь үйлдвэр, ажлын байрыг нэмэгдүүлэн, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх			оруулалт суурь түвшингөөс 2 дахин өссөн байна.				
3.1 3	Аялал жуулчлалын цогцолборуудыг ашиглалтад оруулж менежментийн асуудлыг шийдвэрлэн тухайн цогцолборыг түшиглэн зочид буудал, жуулчны бааз зэргийг байгуулахад газрын асуудлыг шийдвэрлэж ажлын байрыг нэмэгдүүлэх	Ашиглалтад орж газрын асуудлыг шийдвэрлэсэн цогцолборын тоо	0	5 цогцолборын дэргэдэх газрын асуудал шийдвэрлэгдсэн байна	2 тэрбум		БОАЖГ, ГХБХБГ, Дэлгэрхаан, Норовлин, Биндэр, Батноров, Дадал сумын ЗДТГ	Тухайн жилд
3.1 4	"Гэр буудал" төсөл хэрэгжүүлэх замаар орон нутаг аялал жуулчлалыг хөгжүүлэх	Төсөл хэрэгжүүлсэн сумдын тоо, хамрагдсан иргэд, өрхийн тоо		10 хүртэлх сумдад төсөл хэрэгжүүлсэн байна.			БОАЖГ, СЗДТГ	Тухайн жилд

Зорилго 4. Иргэд, олон нийтийн сэтгэлгээ, хандлагад эерэг нөлөө үзүүлэх

4.1	Орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэдэд төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг тогтмол, давтамжтайгаар хүргэх	Олон нийтэд хүргэсэн контентын тоо, түүний хандалт		12 төрлийн контентыг хийж түгээж, 20,000 багагүй хүнд хүргэсэн байна.			АЗДТГ-ын ТЗУХ	Тухайн жилд
4.2	Хэнтий аймагт шилжин ирж амьдарч байгаа иргэдийг сонгон авч "Хөдөө амьдрах сайхан" контент бэлтгэж олон нийтэд түгээх	Контентын тоо, хандалт		10 контент бэлтгэж, 20,000 багагүй хүнд хүргэсэн байна.			АЗДТГ-ын ТЗУХ	Тухайн жилд
4.3	Хувиараа бизнес эрхлэх боломжуудын талаар буюу ажлын байрыг	Бэлтгэсэн контентын тоо, хандалт		Орон нутагт шилжин суурьшиж, амьдарч байгаа 20 хүртэлх			АЗДТГ-ын ТЗУХ	Тухайн жилд

	дэмжих, ЖДБ-ийг дэмжих зээл, орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх			бодит кейсүүдийг сурталчлан, контент болгон бэлтгэж, хандалтыг 20,000 хүргэсэн байна.				
4.4	Их дээд сургуулиудад суралцаж байгаа Хэнтий аймгийн оюутан залуучуудыг орон нутагтаа ирж ажиллаж, амьдрахад уриалах контент бэлтгэх хүргэх	Бэлтгэсэн контентийн тоо, хандалт	0	Тухайн чиглэлээр 14 контент бэлтгэн хандалтын тоог 20,000 хүргэсэн байна.	5 сая төгрөг		АЗДТГ-ын ТЗУХ	Тухайн жилд
Зорилго 5. Иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх								
5.1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод, ТББ, Иргэний нийгмийн байгууллага, телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Хамтран ажилласан ИНБ-ын тоо, гүйцэтгүүлсэн чиг үүрэг		Орон нутагт шилжин суурьшиж, амьдарч байгаа иргэдийн талаар сурталчлах, сайн туршлагыг түгээх зэрэг олон нийтэд чиглэсэн арга хэмжээ, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх			АЗДТГ-ын ТЗУХ	
5.2	Нутгийн зөвлөлтэй хамтран УБ хотод мэдээллийн төвтэй болох	Мэдээллээр хангагдсан иргэд, ААН-ийн тоо		Хэнтий аймаг руу шилжин суурьших хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тогтмол, бодит мэдээллээр хангах мэдээллийн төвтэй болсон байна.			АЗДТГ, нутгийн зөвлөл	3 дугаар улиралд



Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 24-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн

Ахлагч:

Л.Батсайхан

Засаг даргын орлогч

Нарийн бичиг:

Э.Мөнх-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга

Гишүүд:

Ж.Гантулга

Төрийн захиргаа удирдлагын
хэлтсийн дарга

Б.Дарханбаатар

Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Д.Өнөрцэцэг

Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга

Н.Хүрэлээ

Цэргийн штабын дарга

Б.Дархантөр

Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Сүнгээ

Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

А.Гантөмөр

Татварын хэлтсийн дарга

Б.Төрхүү

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Л.Мэндбаяр

Эрүүл мэндийн газрын дарга

С.Мөнхцэцэг

Боловсрол шинжлэх ухааны
газрын дарга

Э.Хонгорзул

Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга

Н.Нямхатан

Нийгмийн даатгалын хэлтсийн
дарга

Сумдын Засаг дарга нар